

ОЙРХИ ҮЕИЙН МОНГОЛЫН ГҮН УХААНЫ СЭТГЭЛГЭЭНИЙ ЗАРИМ АСУУДЛУУД

М.Саранцэцэг(Ph.D)

МУБИС, ТНУС

Философи-дидактикийн Тэнхимийн ахлах багш

Тулхуур үгс: гүн ухаан, философи, бин, монголын гүн ухааны түүхийн үечлэл, нигилист хандлага

“Үндэстэн өөрийгөө байгаагаар нь судлаж өөрөөр хэлбэл өөрөөсөө ургуулан бодох нь чухал. Өөрийгөө мэдэхгүй байж оюунжиж болно гэж санахын ч хэрэггүй.”¹ Монгол үндэстэн XXI зуунд өөрийгөө дааж гарахын тулд хоёр зүйлийг дээд зэргээр анхаарах ёстой. Нэгд.Монгол үндэстэн өөрийгөө болон хүсэл зоригоо ухаарч өөрийнхөө төлөө идэвхитэй тэмцэх цаг тулж ирсэн. Иймд бид үндэстэн мөн гэдгээ зориуд байнга санаж, улс орныхоо тусгаар тогтнолыг хадгалж хамгаалахын төлөө цаг ямагт бүхнийг хийж байх ёстой. Хоёрт.Оюуны тусгаар тогтнолоо улам бэхжүүлж, үндэстний оюунжилтыг дээшлүүлэхэд нэн ул суурьтай, ухаалаг хандаж энэ чиглэлээр үр дүнтэй ажиллах хэрэгтэй. XXI зуунд монгол улс монгол үндэстэн нарийвчлан боловсруулсан бодлого “Үндэсний ухамсар”-таа найдах ёстой. Энэ бол оюун ухаанаа зар, түүндээ найд гэсэн үг хэмээн Б.Даш-Ёндон багшийн бичсэн өгүүллээс энэхүү санаа төрснийг нуух юун.

Монголчууд бид ер нь өөрсдийн түүх, тэр тусмаа монголын гүн ухааны түүхийн талаар хир зэрэг судлаж боловсруулсан билээ гэсэн эргэцүүлэл өөрийн эрхгүй төрсөн билээ. Энэхүү эргэцүүлэлд үндэслэж монголын гүн ухааны түүхийн зарим асуудлыг хөндөх үүднээс монголын гүн ухаан, философи хэмээх ойлголтын тухай, түүхэн үечлэл түүний тодорхой үеийг тусгайлан судлах, ойрхи үеийн монголын гүн ухааны түүхийн хөгжлийг эргэн харах нь өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцнэ хэмээн үзэж байна.

Өнөө үед монголчуудын үндэсний ухамсар сэргэж улс үндэс, тусгаар тогтнол, нийгмийн хөгжлийн тухай хэн хүнгүй ярьж, бичихийн хамт уламжлалт сэтгэлгээ, түүх-соёлоо эрхэмлэн дээдлэх болсон нь нийгмийн зүй ёсны асуудал юм. Нийгмийн энэхүү асуудал нь Монголын гүн ухааны түүхийг дахин судлаж цаашид хөгжүүлэх зорилтыг шаардаж байна. Эрдэмтэн судлаачдын нэг хэсэг нь монголын философийн түүх, нөгөө хэсэг нь монголын гүн ухааны түүх гэх мэтчилэн судалгааны тайлан, эргэцүүлэл, эрдэм шинжилгээний өгүүллийг бичсэн байдаг. Эндээс л бидний дэвшүүлсэн зорилтын зангилаа асуудал харагдаж байна. Иймд юуны өмнө “гүн ухаан”, “философи” хэмээх нэр томъёоны талаар авч үзэх зүйтэй болов уу.

Монголын философийн түүх хэмээн нэрийдэх нь учир дутагдалтай гэж үзэж байна. Учир нь “философи” гэдэг нэр томъёог олон янзаар ойлгон тайлбарлаж бас тодорхойлсон байдгийг бид мэднэ. Тиймийн учир энэхүү өгүүллэгт философийг биш харин гүн ухаан, гүн ухаан болон философийг судлаачид хэрхэн үзсэн талаархи асуудлыг хөндөн тавьж байна.

Гүн ухаан хэмээх нэр томъёо нь дорно дахины ард түмний сэтгэлгээтэй холбогддог бөгөөд монголын түүх, эх сурвалжийг мөшгих харвал “Арван буянт номын цагаан түүх” зохиолд гүн ухаан хэмээх үг:

Б.Даш-Ёндон. Үндэстэн өөрийгөө ухамсарлахын учир. Манай монгол сэтгүүл. УБ., 1999. №3. 16-18 дахь тал

“Өнгөрснийг хөөж онохуйн гүн ухааны бин
Ирээдүйг утгаж онон оточийн бин
Битүүт тааж онох үлэмж мэргэний бин
Одоо ахуйг төгс онохуйн магад мэдэхүйн бин
Аян авын зүйлийг ёсоор мэдэхүйн чадал баатарын бин
Таван ухааныг төгсгөхүй гэгээн билгийн бин хийгээд буюу”² гэж анх дурдагдсан байна.

Долоон их бинг судлаач “Монголын хаадын эрдэм мэдлэгийг эрхэмлэн хүндэтгэх үзэл санааг илэрхийлжээ.”³ хэмээн үзсэн бол судлаач Ж.Энхбаяр “Юуны өмнө тухайн үед аливаа хүн өөрийн язгуур үндэс, гарал угсаа, түүх соёл төдийгүй, гариг дэлхий орчлон ертөнцийн өнгөрснийг танин мэдэх, түүнд тулгуурлаж ёс зүй тогтлыг онон баримжаалах гэсэн утгыг агуулжээ.”⁴ хэмээсэн. Эндээс бид “бин” хэмээх үгийн уламжлалт утгыг харвал монгол хэлний “цэцэн ухаан, мэргэн ухаан” гэсэн утга бөгөөд эдүгээ нэгэнт мартагджээ. Харин практик дээр “гүн ухааныг” философитой дүйлгэн хэрэглэж байгаа явдал нь “философи” үгийн язгуурыг мартагдсан “бин” үгийн утгатай адилтган судалгаа шинжилгээний ажилд хэрэглэсэнтэй холбоотой гэж үзэж байна.

Түүнчлэн “Эрдэний товч” хэмээх судрын төгсгөлийн шүлэгт:

“... Энэ мэт, нэн урьд шүтээн сав ертөнц
Элдэвчлэн гүнээ шүтэгч үр амьтан
Энэтхэгийн олноо өргөгдсөн хаанаас инагш
Эдүгээх тэмцэхүй цагт хүртэл амьтны тул
Богд хүчит хаад төрж, дэлхийг төвшитгөөд
Буянт бодсад нар төрж амьтныг удирдаад
Бурхны шашин богдын төрөөр хотлыг жаргуулсныг
Бүрнээ өгүүлэн эс чадавч төдий товчлон...”⁵ хэмээн уг тогтолцоот үзлийн хүрээ, агуулгыг товч илэрхийлжээ. Энэ бол буддын философийн үүднээс түүхийг авч үзэх бүхэл бүтэн тогтолцоот шинэ үзэл монгол оронд бий болж, аажмаар бүрэлдэн тогтсоныг гэрчлэх баримт юм. Мөн 1925 онд МАХН-ын Төв Хорооны бүгд хурлын тогтоолоор “...Гагцхүү монгол язгуур үндсийг, дэлхийн хувьсгалын их хэргийг бодох хэрэгтэй тул Марксын онол, сурталд олон гишүүд ба ялангуяа залуучуудыг боловсруулбаас эцсийн эцэст их хэрэгт тус дөхөм болно.”⁶ гэж МАХН-ын баримт бичигт заасан байна. Түүнчлэн “... гучаад онд «философия» хэмээх үгийг орос хэлнээс анх удаа Цэвээн гуай орчуулсан.”⁷ хэмээн судлаач Х.Пүрэвтогтох тэмдэглэжээ. Эдгээр баримтууд “гүн ухаан” хэмээх нэр томъёоны хувьслыг илтгэн харуулж байна. Тийм ч учир энэ үеэс эхлэн манай оронд философи хэмээх үг нутагшиж эхэлжээ.

“Гүн ухаан”, “философи” хэмээх нэр томъёоны асуудал нь харилцан адилгүй ойлгогдож ирсэн нь монголын гүн ухаантай холбогдуулан хийсэн судлаачдын бүтээлээс харагддаг. Тэгээд ч энэ тухай эрдэмтэн Ц.Гомбосүрэн “Социализмын жилүүдэд улсын нэр томъёоны комисс гэж албан ёсоор ажиллаж байсны ачаар Орос хэлнээс монгол хэл рүү орчуулсан шинжлэх ухаан, ер

2. Арван буянт номын цагаан түүх. УБ., 1998. 47 дахь тал

3. М.Саранцэцэг. Цагаан түүх зохиол дахь хоёр ёсны үзэл баримтлал. МУИС. Политологи. УБ., 2009. №325 151, 72 дахь тал

4. Ж.Энхбаяр. Монголын философийн түүх судлалын асуудалд. \Философи, эрх зүйн судлал\ XXV. УБ., 2010. 33 дахь тал

5. М.Саранцэцэг. Түүхийн зарим сурвалж дахь философийн асуудлаас. Нийгмийн шинжлэх ухааны залуу эрдэмтэдийн “Хүрэлтогоот-2007” эрдэм шинжилгээний бага хурал. УБ., 2007. 163 дахь тал

6. Монгол Ардын хувьсгалт намын түүхэнд холбогдох баримт бичгүүд. 1920-1940. Нэгдүгээр дэвтэр. УБ., 1966. 131 дэх тал

7. Х.Пүрэвтогтох. Дэлхий дахины философи сэтгэлгээний түвшинд бидний төсөөлөл чухам хаана явна вэ?. Bulletin. УБ., 2003. №1 (31). 63 дахь тал

нь аливаа төрлийн онолын нэр томъёонууд нилээд хэвшиж байсан нь ач холбогдолтой байлаа.⁸ гэж онцолсон байдаг. Энэхүү нэр томъёоны талаар зарчмын ялгаатай гурван төрлийн байр суурь ажиглагдаж байна. Үүнд:

1. Философи, гүн ухаан хоёр харилцан адилгүй
2. Философи, гүн ухаан хоёрыг утга дүйлгэж болох боловч өрнө дорноор ялгаж ашиглах
3. Философи бол гүн ухаан мөн гэсэн үзлүүд юм.

Судлаачийн хувьд философи, гүн ухаан хоёрыг утга дүйлгэж болох боловч өрнө дорноор ялгаж ашиглах нь зүйтэй гэж үздэг. Ийм учираас бид монголын гүн ухаан гэж нэрлэж байх нь зүйтэй юм.

Монголын гүн ухааны түүхийг судлан боловсруулах талаар эрдэмтэн судлаачид багагүй зүйлийг хийсэн. Тухайлбал, монголын гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээний хөгжлийг тусгайлан судлаж боловсруулах ажлын гарааг яах аргагүй эрдэмтэн Ч.Жүгдэр багш тавьсан билээ. Монголын гүн ухааны түүхийн судалгаа 1960 оноос эхлэн бие даан эрчимтэйгээр судлагдаж ирсэн. Энэ судалгааг Р.Нансал хоёр үндсэн чиглэлээр өрнөсөн гэж тэмдэглэжээ.

1. Монголын гүн ухааны тулгуур бичиг судрыг монгол төвд, англи, орос зэрэг хэл дээр шууд ашиглаж манай орны гүн ухааныг системчлэн боловсруулсан явдал юм.
2. Монгол орны нийгмийн хөгжлийн диалектикийн аль нэг анхаарал татсан асуудлыг боловсруулсан.⁹

Эдгээр судалгаа шинжилгээний ажлын зэрэгцээ энэ цаг дор монголын гүн ухааны судалгаа Энэтхэг, буддын гүн ухааны чиглэлээр эрчимтэй судлагдсан. Энэ судалгааны хүрээнд монголын эрдэмтэн мэргэд, сэтгэгчдийн намтар, бүтээлүүд судлагдах болсон. Иймд монголын гүн ухааны түүхийн судалгаа гурван чиглэлээр явагдсан гэж үзэх нь зүйтэй болов уу.

Шинжлэх ухааны академийн философи, социологи, эрх зүйн хүрээлэнгээс эрхлэн нийтэлсэн “Монголын түүхийн зарим асуудал” хамтын сэдэвчлэсэн эмхэтгэлд эх орны гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн үндсэн үе шат, үзэл санааны голлох зарим урсгал чиглэл, зарим гол сэтгэгч хийгээд эх сурвалж судлал, судалгааны арга зүйн зарим асуудлыг хөндөн тавьж судалсан. Монголын гүн ухааны түүхийн хөгжлийг судлаач эрдэмтэд хэд хэдэн үе шат болгон авч үзжээ. Тухайлбал эрдэмтэн Ч.Жүгдэр ХХ зууны эхэн хүртэлх монголын философийн түүхийг анх удаа

1. Эртний монголчуудын сэтгэлгээний тойм (нэн эртнээс ХХII зуун)
2. Монголын нэгдсэн гүрний үеийн нийгэм-улс төр, философи сэтгэлгээний хөгжил (ХIII-ХIV зуун)
3. Феодалын бутрал, феодализм хөгжсөн үеийн нийгэм-улс төрийн сэтгэлгээ (ХV-ХVIII зуун)
4. Феодализмын уналтын үеийн нийгэм-улс төр, философийн сэтгэлгээ (ХIX- ХХ зуун) гэж үечлэн онцлог бүрийг нь тусгайлан судалсан.¹⁰

Эрдэмтэн Т.Содномдаргиа

1. Үүсэл хөгжлийн эхэн үе (нэн эртнээс ХIII зуун)
2. Монголын феодализмын үеийн философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээ, монголын дэвшилтэт ардчилсан үзэлтнүүдийн гүн ухаан, нийгэм улс төрийн сэтгэлгээ (ХIX, ХХ зууны зааг үе)
3. Ардын хувьсгалын дараах үеийн философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээ (1921-80-аад он)
4. Сэргэн мандлын үеийн гүн ухаан нийгэм-улс төрийн үзэл бодол гэсэн үндсэн хэсгээр

8. Ц.Гомбосүрэн. Монголын өнөөгийн философи сэтгэлгээний байдалд холбогдох шүүмжлэлт зарим бодол. | Философичдын симпозиум| УБ., 2004. 21 дэх тал

9. Р.Нансал. Монголын гүн ухааныг бүх шатны сургуульд судлах асуудалд. |Дорно дахины гүн ухааны сэтгэлгээ ба орчин үе| УБ., 1999. №1. 7 дахь тал

10. Ч.Жүгдэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ. УБ., 1987. 7 дахь тал

авч үзэж болохоор байгаа юм.¹¹ гэж үзсэн.

Харин эрдэмтэн Д.Давгадорж нар

1. Эртний монголчуудын гүн ухааны сэтгэлгээ (нэн эртнээс XII зуун)
2. Дундад зууны үеийн монголын гүн ухаан, нийгэм улс төрийн сэтгэлгээ (XII-XX зууны эхэн)
3. XX зууны үеийн монголын гүн ухаан нийгмийн сэтгэлгээ¹² гэж түүхэн үе болгон авч үзэхийг санал болгосон. Эдгээр үечлэлийн тухай жич өгүүлнэ.

Монголын гүн ухаан гэхээр өнөөдөр зарим судлаачид буддын гүн ухаан эсвэл марксист философиор төсөөлүүлж байгаа нь нууц биш. Энэ нь нэгд. XIV-XIX зууны буддын гүн ухаанаар төсөөлж ирсэн бөгөөд ер нь судлаачдын үзэж байгаагаар “Эх сурвалж, судалгааны бүтээлүүдийг нягтлаж үзээд дүгнэхэд, сэтгэлгээний түүхийн арвин баялаг өв уламжлалтай хэдий ч монголчууд буддизмын гурван аймаг сав номтой танилцаж, дөрвөн тогтсон таалал бүхий буддын дотоод ухаанд суралцаж эхэлсэн үеэс л философийн хэлэлцэх сэдэвтэй, хэлэлцүүлдэг номч мэргэдтэй болсон юм.”¹³ гэж үзсэн байдаг. Эрдэмтэн Ч.Ган-Өлзий “Дорно дахины сэтгэлгээний сор болсон эртний энэтхэг ба хятадын гүн ухааны сонгодог онолыг шингээсэн буддизмын цогц сургаал төдийгүй манай философи сэтгэлгээний суурь эх сурвалж, бүрдэл хэсэг нэгэнт болон монголжсон...”¹⁴ хоёрт.1925 онд МАХН-ын Төв Хорооны бүгд хурал марксист онолыг үзэх талаар тогтоол гаргасан боловч “...1940 он хүртэлх хугацаанд К.Маркс, Ф.Энгельс, В.И.Ленин нарын зарим философи бүтээлийн орчуулгыг болон цөөвөр зарим философийн сэдэвт өгүүллийг хэвлэн суртчилах үйл ажиллагаагаар хязгаарлажээ.”¹⁵ гэж эрдэмтэн Ц.Гомбосүрэн тухайн үеийн байдлыг түүхийн баримт түшин өгүүлсэн байдаг. Монголын гүн ухааны судалгаа түүх-соёл, урлаг зэрэг бусад шинжлэх ухааны салбараас харьцангуй хоцрогдож байгаа билээ. Энэ талаар судлаач Р.Нансал монголын гүн ухааны судалгаа маш их хангалтгүй байгаа нь хэд хэдэн шалтгаанаас улбаатай гээд түүнээс “Философийг хэт үзэл сурталжуулсан явдал бол Монголын гүн ухааныг судлахад муу нөлөө үзүүлсэн талтай.”¹⁶ хэмээн онцлосон.

Ер нь монголд 1960-аад оны үед гүн ухааныг системтэй судлан хөгжүүлэх ажил эхэлсэн. Манай орны философийн сургалт 1950-аад оноос эхлэсэн \түүх дурдах\ “1950-аад оноос эхлэн философийн утга зохиолд материалист диалектикийн категорийн асуудлыг хөгжүүн хэлэлцэж байна.”¹⁷ “Манай философичид БНМАУ-д марксизм-ленинизм дэлгэрэн хөгжиж цаашид марксист-ленинист философийн сэтгэлгээ хэрхэн хөгжиж байгааг судлан дүгнэж байна.”¹⁸ гэсэн. “БНМАУ-ын Сайд нарын зөвлөл, МАХН-ын Төв Хорооноос өгсөн чиглэлийн дагуу авч үзээд 1966 оны 12 дугаар сарын 28-ны өдөр \Шинжлэх Ухааны Академийн талаар авах зарим арга хэмжээний тухай\ 464 дүээр тогтоол гаргаж улмаар 1967 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс түүхийн хүрээлэнгийн гүн ухаан, хууль цаазын тасгийн эрхлэгчээр Ч.Жүгдэрийг томилжээ.”¹⁹

11. Т.Содномдаржа. Монголын гүн ухааны хөгжлийн тойм. Гүн ухаан нийгмийн сэтгэлгээ. УБ., 1993. №1. /13/ 3 дахь тал

12. Д.Давгадорж нар. Монголын гүн ухааны сэтгэлгээ судлах асуудалд. \Дорно дахины гүн ухааны сэтгэлгээ ба орчин үе\ УБ., 1999. №1. 13 дахь тал

13. Ж.Энхбаяр. Монголын философийн түүх судлалын асуудалд. \Философи, эрх зүйн судлал\ XXV. УБ., 2010. 37 дахь тал

14. Ч.Ган-Өлзий. Монголын буддизм дахь оюун сэтгэхүйн зохицлын асуудал. Философи, эрх зүйн судлал. XXIV. УБ., 2009. 5 дахь тал

15. Ц.Гомбосүрэн. Философийн боловсролын агуулга нь субъектийхээ онцлогоос хамаарч ирсэн байдлаас. \Түүх ба эдүгээ\, Философи эрхийн судлал. УБ., 2001. XVII. 6 дахь тал

16. Р.Нансал. Монголын гүн ухааныг бүх шатны сургуульд судлах асуудалд. \Дорно дахины гүн ухааны сэтгэлгээ ба орчин үе\ УБ., 1999. №1 7 дахь тал

17. Э.Базаржав. Диалектикийн категориуд ба шинжлэх ухааны нэгтгэн дүгнэхийн хөгжил. Философи эрхийн судлал. УБ., 1977. IT. 10 дахь тал

18. С.Норовсамбуу. Философи, социологи, эрхийн судалгааг социалист байгуулалтын практиктэй нягт холбох нь. Философи, эрхийн судлал. УБ., 1987. 4 дэх тал.

19. Ж.Амарсанаа, А.Жамбал. Шинжлэх ухааны академийн философи, социологи, эрх зүйн хүрээлэн байгуулагдсан

гэж түүхийн сурвалжид тэмдэглэгдэн үлджээ. Энэ утгаар нь хандвал монголын гүн ухааныг системтэй судлах ажил эхэлсэн гэж үзэх бүрэн үндэстэй болно. "Гүн ухааны сэтгэлгээний түүхийн судлал нь марксизм-ленинизм ертөнцийг шинжлэх ухааны үүднээс ойлгох, хувирган өөрчлөх тулгуур онол арга зүй болохыг үзүүлээд зогсохгүй, түүхийг урт удаан хугацааны явцад хүрээлэн буй орчин ахуйтайгаа харьцаж, танин мэдэхийн төлөө явуулсан хүн төрөлхтөний оюун сэтгэлгээний эрэл хайгуулын зүй ёсны үр дүн, гол гол ололтыг тусган харуулахад оршино."²⁰ хэмээн эрдэмтэн Т.Содномдарга тэмдэглэсэн нь бидэнд эх сурвалжаар дамжин ирсэн.

Мөн эдүгээ хүртэл монголын гүн ухааны сурах бичиг /4 боть/, судлаач эрдэмтэдийн нэг сэдэвт бүтээлийг эс тооцвол нэн тал дээр гаргасан бүтээл бараг хомс гэж үзэх талтай. Энэ үеэс эхлэн философийн олон чиглэлийн ном сурах бичиг хэвлэгдэн гарсан байх ба монголын гүн ухааны түүхийн сурах бичиг 1990 онд л хэвлэгдсэн байх жишээтэй. 2010 оноос хойш философийн сурах бичиг, гарын авлага, нэмэлт хэрэглэгдэхүүн хэлбэрээр философийн унших бичгүүд хэдэн арваар гарсан бол монголын гүн ухааны түүхийн мөн төрлийн хэрэглэгдэхүүн хэд хэвлэгдэн гарсан байна гэдэг нь энэ талын судалгаа шинжилгээ хэрхэн явагдаж байгааг илтгэн харуулж байна. Гэхдээ энд судлагдаж олны хүртээл болсон зарим бүтээлийг орхигдуулсан байхыг үгүйсгээгүй болно.

XX зууны зааг дахь монголын гүн ухааны сэтгэлгээний түүхэнд дэвшилтэт ардчилсан үзэлтнүүд тэдний үзэл баримтлал, нийгэм улс төрийн зүтгэлтнүүдийн үзэл санаа нэвт шингэсэн байдаг. Тухайн үетэй холбоотой нийгмийн философийн асуудлыг судлаж шинжилсэн зүйл нилээдгүй байгааг хэлэх нь зүйтэй болов уу. Харин дэвшилтэт ардчилсан үзэлтнүүд болон нийгэм улс төрийн зүтгэлтнүүдийг судлах замаар тэдний сэтгэлгээний төлөвшил, онцлог, өөрчлөлтийг илтгэн харуулах оролдлого, судалгаа хомс байгаа нь энэ талбар дээр судалгаа шинжилгээний ажлыг хийж эхлэх улмаар гүнзгийрүүлж судлах нь зүй ёсны асуудал болж байна. Энэ талаар судлаач Ж.Энхбаяр "... түүхийн философийг нийгмийн философийн агуулгад багтаан судлаж, хүн төрөлхтөний түүхийг формацийн онол ёсоор таван үе шатанд хуваан сурталчилж эхэлсэн нь монголчуудын танин мэдэхүйн хувьд ч, монголын философи сэтгэлгээний хувьд ч чухал ололт дэвшил байлаа."²¹ хэмээн тэмдэглэсэн байна.

Гэтэл 1921 оны ардын хувьсгалаас хойшхи үеийн гүн ухааны түүхийг судлаж, түүний сурвалжийг тусгайлан эмхэтгэж цэгцэлсэн зүйл одоо хүртэл үндсэндээ алга. Түүхийн талаасаа харвал нилээд өвөрмөц үе бөгөөд гадаад дотоодын дарлал мөлжлөгийн эсрэг ард олны хөдөлгөөн өрнөсөн, шашин нийгмийн ёс суртахуун, монгол төр ёсны уламжлал, үндэсний ухамсар сэргэсэн үе байлаа. Энэ тухай "XX зууны эхээр гэхэд монголчууд зах зээлийн амьдралын эргүүлгэд орж байснаа гэтэл энэ зууны бараг дунд үеэс нэг намын үзэл суртлын дор нийгэмчлэгдсэн өмч, төрийн төвлөрсөн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлж 1990 оныг хүртэл явлаа."²² гэж дүгнэжээ. Тэгээд ч энэ үеийн монголын гүн ухааны түүхийн хувьд хамгийн адармаатай үе гэж үзэх үндэстэй.

хийгээд түүний үүсэл, хөгжилд академич Ч.Жүгдэрийн бүтээсэн гавьяат үйлс. Философи, эрх зүйн судлал. ХХ-III. УБ., 2012. 8 дахь тал

20. Т.Содномдарга. Агваандандарын зарим зохиол дахь философи логикийн үзэл. УБ., 1978. 3 дахь тал

21. Ж.Энхбаяр. Монголын философийн түүх. Намын шүүмж. Эрдмийн ертөнц. УБ., 2010. 166 дахь тал

22. Д.Давгдорж нар. Монголын гүн ухааны сэтгэлгээ судлах асуудалд. Дорно дахины гүн ухааны сэтгэлгээ ба орчин үе. УБ., №1. 23 дахь тал

*Д.Дашжамц. Марксизм-Ленинизм монгол дэлгэрч хэрэгжсэн нь [1917-1940]. УБ., 1973. БНМАУ дахь марксист сэтгэлгээний хөгжилт. [1940-1960] УБ., 1978. БНМАУ дахь социалист аж төрөх ёсны төлөвшил, хөгжлийн асуудал. УБ., 1982. Өнгөрсний үлдэгдэл, өнөөгийн сөрөг үзэгдэл, түүнийг даван туулах асуудал. УБ., 1988.

*Ц.Балхаажав. Орчин үеийн монгол орны түүхэн хөгжлийн диалектик. УБ., 1968. БНМАУ-ын ангийн харилцааны хөгжил. УБ., 1972. Марксист-Ленинист философийн үндсүүд. Ред. Ц.Балхаажав. УБ., 1982.

*Б.Даш-Ендон. Марксист-Ленинист философи. Диалектик материализм. Ред. УБ., 1982. Марксист-Ленинист философи. Түүхийн материализм. Ред. УБ., 1975. Философийн эхлэн суралцах бичиг. УБ., 1975. Хөдөлмөрчдийн социалист ухамсарт чанар төлөвших диалектик. УБ., 1980.

Ардын хувьсгал ялснаар монголын гүн ухааны түүхэнд шинэ онол арга зүй бүрэлдэн тогтсон. Өөрөөр хэлбэл марксизм-ленинизмын үзэл санаа төрөл бүрийн сувгаар монгол дэлгэрч эхэлсэн. Энэ чиглэлээр Д.Дашжамц*, Ц.Балхаажав*, Б.Даш-Ёндон* зэрэг эрдэмтэд хэд хэдэн дорвитой судалгаа шинжилгээний бүтээл туурвижээ. Өнөө үед монголын гүн ухааны энэ үеийг хөгжлийн нэг үе болгосон байдаг бөгөөд өгүүлэн буй үеийн гүн ухаан, нийгэм сэтгэлгээний түүхийг цогц байдлаар тууштай судалсан судалгааны ажлууд дутагдаж цаашдаа судлаачаа хүлээж байна. Энэ бүхийг дурдан буй учир гэвэл монголын гүн ухааны талаархи охорхон ойлголтууд нь одоо ч байсаар байгаа билээ. Монголын гүн ухааны талаар ялгаатай хэд хэдэн хандлага байна. Үүнд:

1. Монголчууд өөрийн гэсэн гүн ухаан байхгүй

2. Монгол тусгаар тогтносон улс үндэстэн өөрийн гэсэн гүн ухаантай хэмээн үздэг.

Эрдэмтэн Д.Дашпүрэв "Монголын уламжлалт философи нь бүхэлдээ буддизмын философи сургаалын хүрээнд багтаж байсныг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болов уу" хэмээгээд цааш нь "марксист философи, олон ургалч үзлийн нөлөө монголд түрэн орж ирсэн төдий болохоос монголчуудад үндэсний гүн ухааны тогтолцоо байхгүй"²³ хэмээн тэмдэглэсэн байдаг.

Шинжлэх ухааны философи сэтгүүлд "Монголчууд учир шалтгааны ухааныг(тогтсон таалал. М.С) бүтээсэнгүй, гүн ухааныг бага сонирхдог, тэдний бодож сэтгэх нь сул дорой, дан ганц номноос сурдаг, бие даасан өвөрмөц чанарыг хүндэтгэдэггүй"²⁴ Судлаач Ж.Энхбаяр "Өнөөгийн судалгааны хүрсэн түвшин, монголын философийн түүхийн шилдэг сайн бүтээлүүдийг шүүрдэн нягтлахуйяа, францын рационализм, английн эмпирицизм, германы идеализм, америкийн прагматизм гэдэг шиг тийм тусгай философийн монголчууд онолын номыг боловсруулан гаргаж ирсэн мэдээ баримт үгүй байна. Түүнчлэн буддын философийг үзэж, тайлбар ном зохиол туурвиж байхдаа ч ХХ зуунд материалист философи буюу марксизм-ленинизмын онол номоор замнаж явахдаа ч ямар нэг философийн «изм» бүтээсэнгүй, дэлхийн энгээр яригдах сэтгэгчийн сураг ч гарсангүй."²⁵ гэх мэт тэмдэглэжээ. Энэ нь монголчуудын уламжлаж ирсэн сэтгэлгээтэй холбоотой.

Иймд "Монголын ард түмний философи сэтгэлгээний түүхийн судалгааг цаашид өргөжүүлэх, эрчимжүүлэх, монголын ард түмний нийгэм улс-төр, философи сэтгэлгээний түүхийг бүхэлд нь хамтын хүчээр бүтээх ажлыг эхлэх хэрэгтэй байна. Энэ асуудал бол онол, танин мэдэхүйн төдийгүй, өнөөгийн улс төр, монголын ард түмний түүх-соёлын асуудалд холбогдож байгаа судалгааны чухал чиглэл юм. Энэ тухай эрдэмтэн С.Норовсамбуу "Дорно дахины улс түмэн, нүүдэлчид, түүний дотор монголчууд логик сэтгэхүйг хөгжүүлэх талаар төрөлхийн чадвар мөхөс мэтээр батлахыг оролддог хөрөнгөтний үзэл сурталчдад цохилт болж жинхэнэ монголын ард түмний өөрийн өвөрмөц хийгээд баялаг философи сэтгэхүйг хөгжүүлж ирснийг нотлох ёстой юм. Нөгөө талаар монголын ард түмний дэвшилт сэтгэлгээ нь марксизм-ленинизмыг хүлээн авах үзэл санааны нэг угтвар нөхцөл болсныг харуулах ёстой. Үүнд: монголын философийн түүх судлагчдыг бэлтгэх, хүчийг төвлөрүүлэх, судалгааны чиглэл, төлөвлөлтийг тодорхой болгох нь зүйтэй."²⁶ хэмээн үзсэн.

"Монголчууд бусад ард түмний нэгэн адил философи нийгэм улс төрийн сэтгэлгээг хөгжүүлж, түүнд ертөнцийн юмс үзэгдлийн түгээмэл үндсийг олж тайлбарлах, тэдгээрийн зүй тогтлыг олж харуулахыг эрмэлзсэн ахуйн тухай үзэл, байгаль, нийгэм хийгээд ялангуяа сэтгэхүйн үзэгдэл үйл явцыг танин мэдэхэд чиглэсэн танин мэдэхүйн сургаал, аливаа бүхнийг хувьсал өөрчлөлтөд нь авч тайлбарлахыг зорьсон нарийн диалектик концепци, нийгэм улс төрийн асуудлыг тусгайлан авч тайлбарласан социологийн үзэл баримтлал, түүнчлэн монголчуудын

23. Д.Дашпүрэв. Монголын философи. (Философичдын симпозиум) УБ., 2004. 3 дахь тал

24. ШУА-ийн мэдээ. 1966. №3. 29 дэх тал

25. Ж.Энхбаяр. Монголын философийн түүх судлалын асуудалд. (Философи, эрх зүйн судлал) ХХV. УБ., 2010. 33 дахь тал

26. С.Норовсамбуу. Философи, социологи, эрхийн судалгааг социалист байгуулалтын практиктай нягт холбох нь. Философи, эрхийн судлал. УБ., 1987. 10 дахь тал.

аж байдал, үндэсний онцлогтой нягт уялдаа бүхий ёс зүйн болон гоо зүйн сургаал ойлголтууд нөм багтаж байгаа юм.”²⁷ гэж онцлон тэмдэглэсэн нь улс үндэстэн бүр өөрийн философитой гэдгийг нэг ирэл юм.

Ч.Жүгдэр “Философийн сэтгэлгээг дагнан боловсруулж, хөгжүүлж байдаг тусгай ард түмэн гэж байдаггүй, гагцхүү түүхэн хөгжлийн аль шатанд, нийгэм эдийн засгийн ямар нөхцөлд оршин хөгжиж байгаа зэргээс шалтгаалан ард түмэн бүр хүн төрөлхтөний сэтгэлгээний санд өөр өөрийн зохих хувь нэмрийг оруулах замаар философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээг хөгжүүлж ирсэн түүхтэй, тийм ч жам ёстой.”²⁸ хэмээсэн бол эрдэмтэн Г.Лувсанцэрэн “Аливаа ард түмний бүтээн босгож, хөгжүүлсээр ирсэн эдийн болон оюуны соёлын өв сан, мэдлэг ухааны зүйл нь тухайлж түүний хамгийн нарийн нандин сор шим, охь дээж болсон гүн ухааны сэтгэлгээндээ төвлөрөн хураагдсан байдаг жамтай. Хүн төрөлхтөний соёлын хөгжлийн энэхүү түгээмэл жам ёсон монголын ард түмэнд ч нэгэн адил холбогдох нь эргэлзээгүй юм.”²⁹ хэмээн Ч.Жүгдэр багшийн үзлийг улам лавшруулж өгсөн. Энэ нь улс үндэстэн бүр өөрийн философитой болохыг харуулж байна.

Дээрхийг дүгнэн хэлэхэд монголын гүн ухааны сэтгэлгээний түүхийг судлаж ирсэн өв уламжлалыг дахин олон талаас нь шинжлэн судлахын хамт өнөөгийн сэтгэлгээний онцлог, хэрэгцээтэй уялдуулан нийцүүлж тухайн сэтгэлгээний өвөрмөц байдлыг илрүүлэх нь ихээхэн ач тустай. Мөн монголын ард түмний гүн ухаан сэтгэлгээний өв санг нягтлан шинжлэх явдал эдүгээгийн улс төр, нийгэм-соёлд гүн гүнзгий учир холбогдол бүхий асуудал төдийгүй өнөөгийн сэтгэлгээний хувьд анхааран үзэх чухал зорилтын нэгэн болон тавигдаж байгаа юм. Гэхдээ өмнөх судалгаа болон нэг сэдэвт бүтээлийг хуучирсан, хэвшмэл сэтгэлгээний хэв загварт баригдсан хэмээн үзэж тэдгээрийн судалгаа шинжилгээний үнэ цэнэ буурсан хэмээн үзэж болохгүй. Учир нь тухай үеийн судалгааны материалууд болон бүтээлүүд нь тэр цаг дор гүн ухааны сэтгэлгээний эх сурвалжийг бүрдүүлж байсан. Иймд монголын гүн ухааны түүхийг уламжлал шинэчлэлийг хослуулан судлах нь зүйд нийцэх болов уу. Энэ үндсэн дээр дараах саналыг дэвшүүлж байна. Гүн ухаан судлагдахууныг:

Эх сурвалж, баримт дээр түшиглэн судлах

Бие хүний үзэл баримтлал, үйл ажиллагаанд тулгуурлан судлах

Түүхэн байдалтай нь уялдуулан судлах гэх мэтчлэн гүн ухааны сэтгэлгээг системчлэн тодруулах нь зүйтэй гэж үзэж байна.

“... улмаар манай философийн ухаан тус орны одоогийн хөгжлийн шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна.”³⁰ гэж тухайн үед Ч.Жүгдэр багшийн нийтэлсэн өгүүллийг дахин сануулахад буруудах юун. Бид л өөрсдийнхөө гүн ухааныг судлаж сурталчлахгүй бол хэн бидний өмнөөс хийх юм бэ?.

НОМ ЗҮЙ

1. Ж.Амарсанаа, А.Жамбал. Шинжлэх ухааны академийн философи, социологи, эрх зүйн хүрээлэн байгуулагдсан хийгээд түүний үүсэл, хөгжилд академич Ч.Жүгдэрийн бүтээсэн гавьяат үйлс. Философи, эрх зүйн судлал. XXVII. УБ., 2012

2. Арван буянт номын цагаан түүх. УБ., 1998

3. Ч.Ган-Өлзий. Монголын буддизм дахь оюун сэтгэхүйн зохицлын асуудал. Философи, эрх зүйн судлал. XXIV. УБ., 2009

4. Ц.Гомбосүрэн. Монголын өнөөгийн философи сэтгэлгээний байдалд холбогдох шүүмжлэлт зарим бодол. \Философичдын симпозиум\ УБ., 2004

5. Ц.Гомбосүрэн. Философийн боловсролын агуулга нь субъектийхээ онцлогоос хамаарч

27. Г.Лувсанцэрэн. Монголын философийн түүхийн захим асуудал. УБ., 1990. 4 дэх тал

28. Ч.Жүгдэр. “Монголын философийн түүхийг судлах арга зүйн зарим асуудал” Монголын философийн түүхийг зарим асуудал (Улсын хэвлэлийн газар.) УБ., 1990. 7 дахь тал

29. Г.Лувсанцэрэн. Ноён хутагт Данзан Равжаа. УБ., 1993. 3 дахь тал

30. Ч.Жүгдэр. Манай орны марксист философийн сэтгэлгээ. Үнэн. 1967. №348

ирсэн байдлаас (Түүх ба эдүгээ). Философи эрхийн судлал. XVII. УБ., 2001

6. Б.Даш-Ёндон. Үндэстэн өөрийгөө ухамсарлахын учир. Манай монгол сэтгүүл. УБ., 1999. №3

7. Д.Дашпүрэв. Монголын философи (Философичдын симпозиум) УБ., 2004. 3 дахь тал

8. Ч.Жүгдэр. "Монголын философийн түүхийг судлах арга зүйн зарим асуудал" Монголын философийн түүхийг зарим асуудал (Улсын хэвлэлийн газар.) УБ., 1990

9. Р.Нансал. Монголын гүн ухааныг бүх шатны сургуульд судлах асуудалд (Дорно дахины гүн ухааны сэтгэлгээ ба орчин үе) УБ., 1999

10. М.Саранцэцэг. Түүхийн зарим сурвалж дахь философийн асуудлаас. Нийгмийн шинжлэх ухааны залуу эрдэмтэдийн "Хүрэлтогоот-2007" эрдэм шинжилгээний бага хурал. УБ., 2007

11. М.Саранцэцэг. Цагаан түүх зохиол дахь хоёр ёсны үзэл баримтлал. МУИС. Политологи. №325(51). УБ., 2009

12. Ж.Энхбаяр. Монголын философийн түүх. Номын шүүмж. Эрдмийн ертөнц. УБ., 2010

13. Ж.Энхбаяр. Монголын философийн түүх судлалын асуудалд. Философи, эрх зүйн судлал. XXV. УБ., 2010

SUMMARY

It's much more important to do research on the heritage of philosophical thought history from different sides and find out the specific peculiarities of thoughts combining with current thought characteristics and usages. The issues of studying the heritage of philosophical thought of Mongolian people is considered to be one of the urgent aims that essential to pay more attention to current politics and socio-culture matters and philosophical thought of the country. However, previously done research papers and theses could not be reported as in old style and less valued. Because the source of the philosophical thoughts have been composed of the research materials and works of that period. Therefore it's appropriate to study Mongolian history of philosophy with combination of traditions and innovations.